



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 12 сарын 23 өдөр

Дугаар А/649

Арвайхээр

Нэмэлт ажил гүйцэтгүүлэх гэрээ байгуулах
тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.2, 35 дугаар зүйлийн 35.1.2, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.4, Төсвийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1.в дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэж буй Арвайхээр сумын Нийгмийн эрүүл мэндийн төвийн барилгын засварын ажлын тоо хэмжээнд тусгагдаагүй, ашиглагчийн хүсэлтээр зайлшгүй хийх шаардлагатай ажлуудыг гүйцэтгүүлсүгэй.

2.Дээрх ажилд нэмэлт гэрээ байгуулан, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Т.Ариунболд)-т даалгасугай.

3. Нэмэлт ажилд шаардагдах 17,284,105 (арван долоон сая хоёр зуун наян дөрвөн сая нэг зуун тав) төгрөгийг 2021 оны орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний хэмнэгдсэн зардлаас шийдвэрлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ц.Идэрсайхан)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011101-84